

ЗАВХАН АЙМГИЙН УЛИАСТАЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН

ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 2 сарын 24-ний өдөр

Дугаар 14

Улиастай

**ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ
ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1, 9.2.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

- 1.Улиастай сумын нутаг дэвсгэрт мөрдөгдөх "Айл өрхийн хуурай хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээ"-г нэгдүгээр хавсралтаар, "Албан байгууллага, ААН-ийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээ"-г хоёрдугаар хавсралтаар, "Дуудлагаар хог хаягдал тээвэрлэх автомашины үйлчилгээний тариф"-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
- 2.Батлагдсан хураамжийн хэмжээг Захиргааны ерөнхий хуулийн дагуу Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж хүчин төгөлдөр болсон өдрөөс хэрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга, хотын захирагч(Ч.Наранбат)-д даалгасугай.
- 3.Тогтоол гарсантай холбогдуулан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 37 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
- 4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ИТХ-ын Зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА Д.САРАНЦЭЦЭГ